

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
20 ... оны ... дүгээр сарын ... өдрийн
... дугаар албан бичгийн хавсралт ...

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар:

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын тухай хууль, Монгол улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

ТНБД-ын 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/52 дугаар тушаалаар “УУХҮЯ-ны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийх, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, байгууллагын үндсэн зорилт, чиг үүргүүд нь газар, хэлтсийн чиг үүргүүдэд, нэгжийн чиг үүргүүд нь албан тушаалд бүрэн хуваарилагдсан эсэх, орхигдсон, давхардсан чиг үүрэг байгаа эсэхийг шинжиллээ. Ажлын хэсэг салбарын стратеги төлөвлөлт, бодлого, ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийсний дагуу дүгнэлт гарган, шинэчилсэн хөтөлбөр боловсруулан Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 370 дугаар тогтоолоор “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийг батлууллаа. Хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Яамдын зохион байгуулалтын бүтэц, оронтооных язгаар батлах тухай” Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан Уулуурхай, хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулалтын бүтцийг гүндэслэл болгон боловсруулав.

УУХҮЯ шинэчилсэн бүтцээр 5 газар, 8 хэлтэс, 78 орон тоотой батлагдсан бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар тус яаманд Төрийн өндөр албан тушаалтан 2, Ажлын албаны 4, Төрийн захиргааны 69, Төрийн үйлчилгээний 3 албан тушаалтан ажиллаж байна.

ТАЗСЗ нь Төрийн албаны тухай хуулийн дагуу Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилох заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, 2018 оны жилийн эцсийн байдлаар яамны хэмжээнд түр орлон гүйцэтгэгчгүй, хөлсөөр ажиллах гэрээт ажилтангүй, төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөөгүй албан хаагчгүй буюу 100 хувь төрийн жинхэнэ албан хаагчаар боловсон хүчин, хүний нөөцийг бүрдүүлэн ажиллав.

2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаар:

Салбар зөвлөл нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан Салбар зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэн ажиллалаа.

Салбар зөвлөл нь чиг үүргийнхээ дагуу 2019 онд үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг 5 зорилт, 9 арга хэмжээний хүрээнд 37 ажил үйлчилгээг төлөвлөн салбар зөвлөлийн гишүүдийн саналыг тусган боловсруулж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар дүгнэхэд төлөвлөсөн 37 ажил 99.6 хувьтай биелсэн байна. Төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.

Салбар зөвлөл 2018 онд 14 тогтоол гаргаж, 18 албан бичиг боловсруулан илгээж, 7 удаагийн хуралдааны тэмдэглэл хөтлөн албажуулж бүртгэсэн байна.

Бүртгэл 4 хуудсыг хавсаргав.

3. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал.

Салбар зөвлөлийн 2018 онд 7 удаа хуралдаж, хурлын тэмдэглэл 7, Төрийн албаны зөвлөлд болон бусад газарт 18 албан бичиг, комисс байгуулах тухай 6 тогтоол, нэр дэвшүүлэх тухай 7, ёс зүйн хороог шинэчлэн байгуулах 1, нийт 14 тогтоол гаргасан байна. Хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтлөн албажуулан бүртгэж, тусгай хавтсанд дугаарлан хадгалж байна.

1. “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдах албан хаагчдыг нэр дэвшүүлэх асуудлыг 1-р хуралданаар шийдвэрлэсэн байна.
2. Салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хоёрдугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.
3. Салбар зөвлөлийн 3-р хуралдааныг 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын өрөөнд Салбар зөвлөлийн ажлын албаны дарга удирдан явууллаа. Хурлаар УУХҮЯ-ны ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Молорын Аясгаланг томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төслийг баталж, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.
4. Салбар зөвлөлийн 4-р хуралдааныг 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 16.00 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын өрөөнд Салбар зөвлөлийн ажлын албаны дарга удирдан явууллаа. Хурлаар УУХҮЯ-ны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын Техник

технологийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Болдбаатарын Ачитсайханыг томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төслийг баталж, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

5. Салбар зөвлөлийн 5-р хуралдааныг 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 14.00 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын өрөөнд Салбар зөвлөлийн дарга Г.Нандинжаргал удирдан явууллаа. Хурлаар АМГТГ-ын:

- Газрын тосны ашиглалтын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Сангарагчаагийн Пүрэвжав,

- Кадастрын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Даваадашын Дашзэвэг,

- Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Бат-Очирын Буянзаяа,

- Геологи, хайгуулын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Бямбаагийн Сүнжидмаа нарыг томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төслийг баталж, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

6. Салбар зөвлөлийн 6-р хуралдааныг 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 16.30 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын өрөөнд Салбар зөвлөлийн ажлын албаны дарга удирдан явууллаа. Хурлаар УУХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн даргын албан тушаалд нэр Д.Лхамжав, АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн даргаар Н.Энхцогтыг томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төслийг баталж, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Салбар зөвлөлийн 7-р хуралдааныг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 16.20 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын өрөөнд Салбар зөвлөлийн ажлын албаны дарга удирдан явууллаа. Хурлаар УУХҮЯ-ны шинээр батлагдсан бүтцийн Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын Эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтсийн даргын албан тушаалд Н.Энхбаяр, Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Газрын тосны хэлтсийн даргын албан тушаалд Ч.Хишигдалай, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Геологийн хэлтсийн даргаар, Адъяагийн Дэлгэрсайхан, Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүнд үйлдвэрийн хэлтсийн даргын албан тушаалд Сүхбаатарын Сүхбат нарыг томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төслийг баталж, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг нь УИХ-ын 2013 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”, “в” заалтыг үндэслэн яамны газар, хэлтсийн дарга нарын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудас болон яамны мэдээллийн самбарт тогтмол байршуулан ил тод мэдээлж байна.

4. Салбарын хэмжээнд хууль журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн

Төрийналбанытухай хуулинд төрийн албаны стандартыг томъёолсны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь төрийнзахиргааны төв байгууллагынчигүүргээ хэрэгжүүлэх, төрийналбанхаагчийнүйлажиллагаагоновчтойзохионбайгуулах, төрийналбанхаагчалбантушаалынбүрэнэрхээхэрэгжүүлэх, төрийнүйлчилгээнийүрашиг, үрнөлөөгдээшлүүлэхэдчиглэсэнүйлажиллагаа явуулж байна.

5. Салбарын хэмжээнд хууль журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/221 дүгээр тушаалаар батлагдсан “Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, үнэлэлтдүгнэлт өгөх” үүрэг бүхий ажлын хэсэг 2017 оны 12 дугаар сараас 2018 оны 1 дүгээр сарыг дуустал агентлаг дээр ажилласан. Ажлын хэсэг АМГТГ-ын даргын 2016.08.01-ний өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд батлан гаргасан боловсон хүчин болон үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалууд холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт, шинжилгээ хийж, 5 тушаал зөрчилтэй гарсан дүгнэлт гаргасан.

6. Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүнгийн талаар:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам боловсон хүчин, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд яам, харъяа агентлаг хамтран 2017-2020 онд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан, Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/140 дүгээр тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Батлагдсан хөтөлбөр нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д заасан төрийн албан хаагчийн баталгааг хангах, хүний нөөц бүрдүүлэх, бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоо бий болгох, яам, агентлагийн удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилготой. Хөтөлбөрийн дагуу жил бүр яам, агентлаг тус тусдаа сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, урт, дунд, богино хугацааны болон ажлын байр дахь сургалтуудыг зохион байгуулж байна.

Ашигт малтмал, газрын тосны газар нь Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнд салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тусгай заалтыг батлуулдаг бөгөөд, гэрээний дагуу сургалтын дансанд хөрөнгө төвлөрүүлж, жил бүр сургалтын зардлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан УУХҮЯ-ны ТНБД-аар батлуулан, төлөвлөсний дагуу зарцуулдаг. 2018 оны салбарын сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө өгч, хамтран ажиллан, ТНБД-ын 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/57 дугаар тушаалаар

сургалтын нэгдсэн төлөвлөгөөг батлуулав. Батлагдсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан “УУХҮЯ-ны албан хаагчдын 2018 оны сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, уг төлөвлөгөөний дагуу 2018 онд төлөвлөсөн 24 сургалтаас 23-ыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв.

- Бодлогын газрууд тус тусын чиглэлээр 4 сургалтыг хариуцан зохион байгуулах,
- 2 төрийн албан хаагчид магистрын сургалтын төлбөр олгоход дэмжлэг үзүүлэв.
- Удирдлагын академийн Төрийн захиргааны удирдлагын мэргэшүүлэх сургалтанд 2 албан хаагч хамрагдаж байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд МУИС, ШУТИС болон бусад их дээд сургуульд магистрын сургалтад 6 албан хаагч хамрагдаж байгаа бөгөөд ТНБД-ын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Чөлөө олгох тухай Б/126 дугаар тушаалаар тэдэнд хичээлийн жилийн хугацаанд ажлын 15-48 өдрийн цалинтай чөлөө олгож, сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэв.
- 7 хоног бүрийн Баасан гаригт 09.00-10.00 цагийн хооронд мэдээллийн цагийг тогтмол ажиллуулж, сонирхолтой хичээл сургалт зохион байгуулж, мэдээлэл өгөхөд туслалцаа, дэмжлэг үзүүлж байна.

2018 онд яамнаас гадаадад 15, дотоодод 58 албан хаагч /давхардсан тоогоор/ богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байна.

7.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг хангах талаар зохион байгуулсан ажил, үр дүнгийн талаар:

“УУХҮЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг ТНБД-ын 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/32 дугаар тушаалаар шинэчлэн баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөнд 19 ажил төлөвлөснөөс 18 ажил хэрэгжсэн байна. Төсөв, санхүүгийн боломжгүй байдлаас шалтгаалан албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажил хэрэгжээгүй тул Ажиллагсдын эрүүл мэндийн боловсролд зориулан 2 удаагийн сургалт мэдээлэл хийж, ажлын цагийг хэмнэх, тавтхуйтай үйлчилгээ авах зорилгоор ажлын байранд ээрт одорхой төрлүүдээр /цусны дэлгэрэнгүй, сахарын, Д-витамины зэрэг/ шинжилгээ авч, хүннэг бүрт тусгайлан шинжилгээний хариуг хүргэж, зөвлөгөө өгөх, дахин шинжилгээнд харуулах зэрэг ажлуудыг хийлээ.

- Төлөвлөгөөний дагуу:
- Цасны баяр, яамны спортын уралдаан тэмцээн, явган аялал-зугаалга зохион байгуулж, ажиллагсдыг биен тамир спортоор хичээллэх боломжоор ханган спорт заал түрээслэн ажиллаж байна.
- Хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажиллагсдад тусламж, дэмжлэг үзүүлэх 18, гадаадад сургалтад хамруулах 2, хүүхэд асрах болон цалинтай цалингүй чөлөө олгох 31, нийт албан хаагчдын цалингийн шатлал зэрэглэл ахиулах болон зарим ажилтны цалинтай холбоотой 3 тушаал тус тус гаргаж, өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн байна.
- 2018 оны сургалтын төлөвлөгөөний дагуу:
- Салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг 2018 оны сургалтын сонгон шалгаруулалтаар тус яамны 2, Ашигт малтмал, газрын тосны газрын 2 төрийн албан хаагчид гадаадад магистрт тэтгэлэгтэй суралцах эрх олгов.

- Мөн тус яамны 2 төрийн албан хаагчийн магистрын сургалтын төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

- 7 хоног бүрийн Баасангаригт 09.00-10.00 цагийн хооронд мэдээллийн цагийг тогтмолажиллуулж, сонирхолтой хичээл сургалт зохион байгуулж, мэдээлэл өгөхөд туслалцаа, дэмжлэг үзүүлж байна. Ажиллагсдынажиллах нөхцөл бололцоог сайжруулахын тулд бүх компьютер, техник хэрэгслийг шинэчлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах төсвийг 2019 оны төсөвт суулгасан.

8. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод байдлыг хангасан байдал, үр дүн

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу Салбар зөвлөл тус яамны 2018 онд Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах 6 комиссыг ТАЗСЗ-ийн тогтоолоор байгуулан ажиллаж, дараах удирдах албан тушаалд томилуулав. Үүнд: УУХҮЯ-ны

- Уул уурхайн бодлогын газрын дарга,
 - Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
 - ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга,
 - ХҮБГ-ын Техник, технологийн хэлтсийн дарга,
 - ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга,
- АМГТГ-ын 6 хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшигчдийг сорилын шалгалтад оролцуулах хүсэлтийг холбогдох материалын хамт ТАЗ-д хүргүүлэн, удирдах ажилтны сорилын шалгалтад оролцуулан, салбар зөвлөлийн шийдвэр гаргуулж, тус тусын нэр дэвшсэн албан тушаалд томилуулав.
- Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “УУХҮЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 370 дугаар тогтоол батлагдсантай холбоотой шинээр удирдах албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулав.

Дараах 3 газрын даргын албан тушаалд:

- Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга
- Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргад нэр дэвшигчийн танилцуулга, бичиг баримтыг журмын дагуу бүрдүүлэн ТАЗ-д хүргүүлэн удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцуулан тогтоол шийдвэр гаргуулж, мөн дараах 4 хэлтсийн даргын албан тушаалд:
- Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга,
- Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Геологийн хэлтсийн дарга,
- Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүнд үйлдвэрийн хэлтсийн дарга
- Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Газрын тосны хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчдийг ТАЗ дээр удирдах ажилтны сонгон

шалгаруулалтын сорилын шалгалт, ТАЗСЗ дээр ерөнхий болон ярилцлагын шалгалттуудыг зохион байгуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт, тогтоол гарган тус тусын нэр дэвшсэн албан тушаалд томилуулах ажлыг зохион байгуулав.

9.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэрдэвшүүлсэн ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

2018 онд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4 дэх заалтын дагуу яамны сул ажлын байранд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө төрийн албаны МЕРИТ зарчмыг баримтлан харьяа агентлаг буюу Ашигт малтмал, газрын тосны газраасб, бусад төрийн байгууллагаас 13,төрийн албаны шалгалт өгөн, төрийн албанд анхорох иргэний нөөцөд бүртгэгдсэн 1, нийт 20төрийн захиргааны албан хаагчийг холбогдох албан тушаалд томилсон байна.

Хүснэгт №1

№	Тушаал дугаар	Тушаал ыногноо	Тушаалынагуулга	Ажиллажбайсанбайгууллага
1	Б/01	2018.01.05	БатбаярынБатцэцэгийгажилдтом илохтухай	Сонгинохайрхандүүргийн ЗДТГ
2	Б/10	2018.01.18	Ажилдтомилохтухай /О.Энхбаяр/	Ашигтмалтмал, газрынтосныгазар
3	Б/14	2018.01.29	Ажилдтомилохтухай /П.Сарангэрэл/	Газрынтосныгазар, УУХҮЯ-нытөсөл
4	Б/26	2018.02.15	АжилдтомилохтухайБ.Дэлгэржарг алыгмэргэжилтнээртомилох	Ашигтмалтмал, газрынтосныгазар
5	Б/28	2018.02.15	Сэр-ОдынГан-Очирыгажилдтомилохтухай	АМГ, УУЯ, Бор-Өндөрийн УБҮ
6	Б/29	2018.02.15	Түрорлонгүйцэтгэгчтомилох /М.Аясгалан/	Сангийняам
7	Б/33	2018.02.22	Ажилдтомилохтухай /ШомборынУранчимэг/	Ашигтмалтмал, газрынтосныгазар
8	Б/60	2018.05.09	Ажилдтомилохтухай /Г.Мишээлт/	Үндэснийхөгжлийнгазар
9	Б/84	2018.08.01	Ажилдтомилохтухай /Ц.Түмэнцогт/	Эрдэнэставантолгой ТӨХХК
10	Б/86	2018.08.01	Ажилдтомилохтухай /Д.Лхамжав/	Сангийняам
11	Б/87	2018.08.09	Ажилдтомилохтухай /Д.Жадамба/	Нийслэлийнпрокурорынгазар
12	Б/124	2018.10.26	Ажилдтомилохтухай /Б.Амарзаяа/	Нийслэлийнбаялалжуулчлалынгазар
13	Б/125	2018.10.26	Ажилдтомилохтухай /Г.Намчинсүрэн/	УУХҮЯ, /Төрийнүйлчилгээ/

14	Б/156	2018.12.31	Ажилдтомилохтухай /Э.Батболд/	Санхүүгийнзохицуулаххороо
15	Б/158	2018.12.31	Ажилдтомилохтухай /С.Сүхбат/	Усныгазар
16	Б/160	2018.12.31	Ажилдтомилохтухай /Э.Болд-Эрдэнэ/	Уулуурхайнсалбар
17	Б/161	2018.12.31	Ажилдтомилохтухай /Ч.Хишигдалай/	Ашигтмалтмал, газрынтосныгазар
18	Б/164	2018.12.31	Ажилдтомилохтухай /А.Дэлгэрсайхан/	Ашигтмалтмал, газрынтосныгазар
19	Б/165	2018.12.31	Ажилдтомилохтухай /Г.Ганхүү/	СонгинохайрхандүүргийнМэргэжлийнхяналтынхэлтэс
20	Б/166	2018.12.31	Ажилдтомилохтухай /Б.Туул/	УУХҮЯ, /Төрийнүйлчилгээ/

10. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлэлт, түүгээр үйлчилсэн байдал

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн санд 2018 онд бүртгэгдсэн албан хаагч байхгүй.

11. Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлэлт, түүгээр үйлчилсэн байдал

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл болон бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 23.3.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй 6 иргэн байна.

Хүснэгт №2

№	Тушаалд угаар	Чөлөөлсөн тушаалын огноо	Тушаалынагуулга	Тайлбар
1	Б/38	2017.09.25	Ажлаасчөлөөлөхтухай	А.СодбилэгЯпондсуралцахболсонтул ТА-нынөөцөдавах
2	Б/43	2018.03.19	Ажлаасчөлөөлөхтухай /Д.Оюунсайхан/	Өөрийнхүсэлтээрсуралцахболсонтултөрийн албанаастүрчөлөөлж, нөөцөд бүртгэх
3	Б/74	2018.06.18	Ажлаасчөлөөлөхтухай /Б.Солонго/	Өөрийнхүсэлтээрсуралцахболсонтултөрийн албанаастүрчөлөөлж, төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэх
4	Б/94	2018.08.28	Ажлаасчөлөөлөхтухай /Б.Уужим-Ухаан/	Өөрийнхүсэлтээрсуралцахболсонтултөрийн албанаастүрчөлөөлөв

5	Б/127	2018.10.2 6	Төрийналбанаастү рчөлөөлж, нөөцөдбүртгэхтуха й /Н.Баярчимэг/	Суралцахболсонтулөөрийнхүсэлтээртөрийн албанаастүрчөлөөлж, төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэх
6	Б/130	2018.10.3 1	Төрийналбанаастү рчөлөөлж, нөөцөдбүртгэхтуха й /Б.Мягмардаваа/	Суралцахболсонтулөөрийнхүсэлтээртөрийн албанаастүрчөлөөлж, төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэх

12. Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлын мэргэшлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцсон байдал

Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн яам, агентлагийн төсвийн шууд захирагч, менежер болон төрийн жинхэнэ албан хаагчидтай 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг нь үнэлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газар, төсвийн шууд захирагч нар нь Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай 2018 онд үр дүнгийн гэрээ байгуулан гэрээнд байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гэрээний салшгүй хэсэг болгон нийт болон тусгай ажил, үйлчилгээнүүд, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-үүд болон бусад эрх үүргийг тусган хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тооцож үнэлэлт өгч ажилласан.

2018 онд УУХҮЯ-ны 68 төрийн захиргааны албан хаагч Үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан бөгөөд жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлэхэд А үнэлгээ авсан 50, В үнэлгээ авсан 15 албан хаагч байна. 2018 оны 10, 11 дүгээр сард өөр ажилд шилжсэн буюу суралцахаар чөлөөлөгдсөн 3 албан хаагч ҮДГ биелэлт гаргаагүй болно.

Төсвийн шууд захирагч нарын үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг сайдын зөвлөлийн хурал болон Төрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

13. Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч ажилласан байдал, үр дүн

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан "Ёс зүйн хороо" 3 дахь жилдээ ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавин ёс зүйн дүрмийн мөрдөж ажиллах талаар албан хаагчдаас баталгаа гаргуулан мөрдөж байна.

Засгийнгазрын 2016-2020 оныүйлажиллагааныхөтөлбөрийгхэрэгжүүлэхажлыгэрчимжүүлэхзорилгоорМонголУлсынЗасгийнгазрын 2018 оны 1 дүгээрсарын 31-ний өдрийн 32 дугаартогтоолоор 2018оныг “Хариуцлагынжил” болгонзарласан..

“Хариуцлагынжил”-ийнхүрээндУул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар гарч, сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллаж байна.

Яамны Төрийн захиргааны удирдлагын газраас ажиллагсдын ажлын цаг ашиглалт, хоцролт, ажлын байрны эмх цэгц, хариуцлагыг дээшлүүлэх тал дээр хяналт тавин ажиллаж, ажиллагсдыг мэдээллээр ханган ажилласны дүнд сахилга хариуцлага дээшилж, ажлын цаг ашиглалт эрс сайжирч, ажилд ахиц дэвшил гарсан.

Ашигт малтмал, газрын тосны газрын Ёс зүйн хороо 2018 онд бүрэлдэхүүнээ шинэчлэн, 10 хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн хороог газрын даргын 2018 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А/102 дугаар тушаалаар багуулсан.

АМГТГ-ын Ёс зүйн хороо энэ онд 7 удаа хуралдаж, давхардсан тоогоор 15 төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн зөрчлийг авч хэлэлцсэн байна.

Яам, агентлаг “Сахилгахариуцлага, дэгжурмыгчангатгахтухай” Засгийнгазрын 2017 оны 10 дугаарсарын 26-ны өдрийн 1 дүгээралбандаалгавар, “Хариуцлагынжил”-ийнхүрээндУул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаварынхэрэгжилтийгханганажиллажбайна.

14. Өргөдөл, гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас бүтэн жилээр гаргасан байдал

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд2018 оны жилийн эцсийн байдлаар ирсэн өргөдөл, гомдол байхгүй.

2018 онд хариуцлага, ёс зүйн алдаа гаргасан буюу удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ү.Ганбатаарт ТНБД-ын 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн Б/32 дугаар тушаалаарсануулах сахилгын арга хэмжээ авсан. Уг арга хэмжээ нь газрын даргын санаачлага, ажлын цаг ашиглалтад хийсэн удаа дараагийн хяналт шалгалтаар тогтоогдсон тул зөрчлийг арилгуулах зорилгоор авагдсан болно.

Ёс зүйн хороодын 2018 оны ажлын тайланг хавсаргав.

15.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал

Салбар зөвлөлийн хуралдааны тойм болон Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн гаргасан журмууд болон Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан болон хүний нөөцтэй холбоотой мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны mmhi.gov.mn сайтад **Ил тод байдал** гэсэн буланд “Хүний нөөц” гэсэн цэсэнд байршуулсан.

16. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан,мэдээ гаргасан байдал

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн хуваарийн дагуу хугацаанд нь буюу 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр цахимаар гаргаж ТАЗ-ийн Ажлын албаны шинжээч М.Алтанбаганад хүргүүлсэн. Тайланд 78 төрийн албан хаагч хамрагдсан.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны программ хангамж, техник хангамж, сүлжээг бүрэн ашиглаж байна. “Able” программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж хүний нөөцийн удирдлагын программыг суулгаж мэдээллийг тогтмол ашиглаж байна.

Энэхүү программаар ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлан мэдээ, үүрэг даалгавар түүний биелэлт, ажлын цагийн ашиглалт, хууль, эрх зүйн мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл, форум хэлэлцүүлэг, архив бичиг хэрэг зэрэг олон мэдээллийг авах харилцах боломж бүрдсэн.

17. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил

УУХҮЯ нь 2018 онд яамны хүний нөөц-боловсон хүчнийг зөв зохион байгуулалтаар удирдах, чадавхжуулах зорилт дэвшүүлэн ажиллаж, мэргэжлийн газар, хэлтэс нэгжүүддээ төрийн албан хаагчдыг эзэмшсэн мэргэжил, дадлага туршлага, мэргэшсэн байдлыг харгалзан томилж, зохион байгуулалтын шинэ бүтцэд шилжсэн.

Салбар зөвлөл үүргийнхээ дагуу төрийн албан хаагчдыг төрийн албаны тухай хуульд заасан ерөнхий болон тусгай шалгуурыг хангасан байдал, ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэх чадвар, туршлага, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн, ажлаа тайлагнасан байдал зэрэгт дүгнэлт гарган, шинэ томилгоонд зөвлөмж, чиглэл өгч ажилласан.

УУХҮЯ-ны батлагдсан 78 орон тоонд Төрийн өндөр албан тушаалтан 2, Ажлын албаны 4, Төрийн захиргааны 69, Төрийн үйлчилгээний 3 албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд Төрийн захиргааны 69 албан хаагч нь бүгд төрийн албан хаагчийн тангараг өргөсөн, төрийн жинхэнэ албан хаагчид болсон нь салбар зөвлөлийн үйл ажиллагаа эрчимжсэн, хуулийн хэрэгжилт сайн байгааг илтгэж байгаа үзүүлэлт юм. Нийт албан хаагчдын албан тушаал, мэргэжил, мэргэшил, туршлагын мэдээллийг хавсаргав.

18. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийт, иргэдийн үнэлгээ

Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол, хүсэлт 2018 онд ирээгүй бөгөөд яамны үүдэнд олон нийт, иргдээс санал хүсэлт хүлэн авах нээлттэй хайрцаг байршуулсан.

19. Салбар зөвлөлийн ажлын тайлан гаргасан байдал

Салбар зөвлөл УУХҮЯ-ны төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг бүтэн жилээр, үйл ажиллагааны тайланг 2017 оны жилийн эцсээр гарган 2018

оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 03/01 тоот албан бичгээр, салбар зөвлөлийн 2018 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланг 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 03/07 дугаар албан тоотоор Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлсэн.

20.Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт

Төрийн албаны зөвлөлөөс Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулалтыг хойшлуулах тухай 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 707 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврыг биелүүлэн, удирдах албан тушаалд нэр дэвшигчдийн бичиг баримтын үнэлгээ, ерөнхий шаардлагыг хангасан байдлыг нотлох баримтуудыг ТАЗ-ийн зөвлөмжийн дагуу бүрдүүлэн хүргүүлж, заасан хугацаанд нь шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.

ТАНИЛЦСАН:

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА

М.БАЯРАА

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:
САЛБАР ЗӨВЛӨЛИЙННАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ш.УРАНЧИМЭГ